# ПАК ЖОНГ ХЫЙ-ГИЙН ЗАСАГЛАЛЫН ЭРХ МЭДЛИЙН БҮТЭЦ БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ОНЦЛОГ

***Ж.ТӨРТОГТОХ***
*Доктор, профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар, Улс төр судлалын тэнхим*
***ПАК ЖОНГ ХУ***
*Докторант*

**Abstract:** In the administration of former President Park chung-hee, the role of the legislative branch was weak compare with government agencies which operated by president park's aide. President Park Chung-hee was focused on economic development in order to justify the lack of the power legitimacy after the coup. As a result, all the state power has been focused on president Park Chung-hee. And concentrated power was implemented by some people close to the president. The foreign exchange is necessary for development of economy. So despite of the opposition of the people, president park was negotiations with Japan to obtain reparations and loans. And by dispatched of troops to the Vietnam war, could received financial support from the United States. But economic performance of Park Chung-hee regime might trigger the people's resistance bigger. Rapid industrialization strengthening the power of democracy, strengthened public opinion opposed to dictatorship of Park Chung-hee. The economic policy of park's presidency left two legacies in the viewpoint of social justice.

First, after park's regime, the government's national goals are focusing on economic development rather than realize social justice. Second, South Korea's conglomerates had grown under the president park's regime. By Given the various benefits and government support from the president park chung-hee. As a result, conglomerates has been established a rigid system. On the other hand, democratic social systems which check and control for conglomerates, did not fully grown until the present.

********

## 1. Улс төрийн элитийн ойлголт болон хамрах хүрээ

Ямарч нийгэмд эрх мэдэл нь жигд бус хуваарилагддаг нь бодит байдал байдаг учир, "бусад хүмүүсээс илүү их улс төрийн эрх мэдэлтэй хүмүүс" хэмээн тодорхойлогддог улс төрийн элит ямарч үе, ямарч нийгэмд оршдог.[1] Гэвч бодит байдал дээр хэн улс төрийн элитийн үүргийг гүйцэтгэж байгаа вэ гэдэг тал дээр хүмүүсийн үзэл бодолд ялгарал гардаг. Нийтлэгээр үүрэгт хэсэг болон хүн дүүргэх онолын өөр байдалд суурилан эрх мэдэлт элитийг ерөнхийлөгчийн ойр дотны тал, үндсэн намын томилсон албан тушаал, эдийн засгийн хэсгийн дарга зэрэгээр ангилан харах боломжтой.

Гэвч энэ судалгааны судлах хүрээ болдог Пак Жонг Хый-гын засаглалын үед хууль тогтоох газрын үүрэг бага байгаа боловч, засаглалыг оршин тогтнуулах болон дахин боловсруулахад зориулагдсан хэсэг төрийн байгууллагат эрх мэдэл төвлөрсөн байсан ба, эрх мэдэлт байгууллагын дарга нь ихэвчлэн Пак Жонг Хый ерөнхийлөгчийн хамгийн дотны хүмүүс хийдэг байсан. Тиймээс судалгааны ажилын судлах хүрээ болон Пак Жонг Хый ерөнхийлөгчийн үеийн захирах элитийн талаарх анализ нь хамгийн дотны хүмүүсээс томилогдсон эрх мэдэлт байгууллагын даргуудыг судлана. Мөн Пак Жонг Хый ерөнхийлөгчийг удаан хугацааны туршид засаглал барих боломжтой болгосон эдийн засгийн бодлогыг улс төрийн эдийн засгийн талаас судлах гэж байна.

## 2. 5.16 Цэргийн бослого болон улс төрийн элит

Өнгөрсөн цагт, шинэ байгуулагдсан улсын орчин үед нийцсэн улс болгох үйл ажиллагааны үед улс төрийн удирдагч юм уу эрдэмтэнээс илүү улсад илүү том нөлөө үзүүлсэн бүлэг хүмүүс байсан ба эд нар нь цэргийн албан тушаалтан юм. Шинээр тусгаар тогтносон улсад улс төрийн систем бүрэлдэх шатанд байдаг ба, улс төрийн эрх мэдэл хараахан батжаагүй байгаа тогтворт бус байдалтай учир хүчийг шууд байдлаар хэрэглэх боломжтой хүмүүс жинхэнэ утгаар тухайн улсын хувь тавиланг шийдвэрлэдэг чухал шийдвэрийг гаргах болдог. Эд нар цэргийн албан тушаалтан улс төрийн байдалд оролцох хүчин зүйлээр цэргийн албан тушаалтангуудын авч байсан боловсролын уламжлалт онцлого, цэргийн албан тушаалтаны нийгмийн гарал үндэс, цэргийн талаарх албан тушаалтаны захирах хүрээ болон, мөн нэг

[1] Putnam Robert D. 1976. The Comparative Study of Political Elite., Englewood Cliffs, N.J. :Prentice Hall, p5

талаас жирийн улс төрийн удирдагчдын удирдах чадвар болон цэргийн удирдагч хоорондын холбоот байдалд гарах онцлого зэргийг хэлэх боломжтой.[2] Тусгаар тогтнолын дараа шинэ улсаас өөрчлөлтийг давтан ирсэн улс төрийн удирдагчын ул мөрийг 3 үе шат болгон ангилах боломжтой. Эхний үе шат нь ерөнхийдөө 1950 оны эхэн хүртэл үргэлжилсэн Европын ардчилалын орж ирэх үе бөгөөд, хоёр дахь шат нь 1950 оны сүүлд бүрэн бүрэлдсэн нэг хүний захиргаадах байдалын батжил юм. Гурав дахь шат нь 1950 оны сүүлд тухайн газарт үүссэн цэргийн бослогын элбэг болох үе хэмээн ангилагддаг.[3] Мэдээж бүх шинээр байгуулагдсан улсууд дээрх гурван үе шатыг дамжсан бол биш. Азид энэ гурван шатыг дараалаар дамжсан улсуудыг хайж үзвэл, Индонез, Хуучин Вьетнам, Солонгос зэргийг хамруулах боломжтой.

Пак Жонг Хый нь хэсэг цэргийн бүлэгтэй хамт 1961 оны 5 сарын 16-нд цэргийн бослого гаргасан. Цэргийн бослогын албан ёсны шалтган нь бослогоор дамжуулан ялзарсан чадваргүй тухайн үеийн улс төрийн элитүүдийг устгахад орших байсан. Үүнийг даган Пак Жонг Хый болон цэргийн хэсэг нь тухайн үеийн улс төрийн эрх мэдэлтэнгүүдийг устгасан ба, хамтарсан хүмүүсээр цэргийн нэг хүний эрх мэдэлт засаглалын суурийг босгосон. Бослогын дараа, 30-аад хүний цэрэг, эсвэл тэд нарыг төвөө болгосон хүчтэй бүлэг хүмүүс Солонгосын шийдвэрлэх эрхийг эдлэсэн. УИХ болон нам түр хугацаагаар хаагдсан ба, бүх сонгуул нь дор хаяж 2 жилээс илүүгээр хүлээгдсэн. Орон нутгын байгуулгын дарга нь сонгуулийн тогтолцооноос томилолтын тогтолцоо болон өөрчлөгдсөн.

5.16 Бослогын гол төвийг бүрдүүлсэн цэргийн элитүүд бослогын дараа улс төрийн элит болж орчин үетэй хөл нийлэх бодлогыг явуулах болдог. Тухайн үед шинээр гарч ирсэн орчин үечлэл гэдэг нь аж үйлдвэрчлэлийг илэрхийлсэн ба мөн аж үйлдвэрчлэл л үүсвэл бүх асуудал шийдвэрлэгдэнэ гэсэн ойлголт үүссэн. Шинэ байгуулагдсан улсын тогтворгүй байдлын үндэс нь эдийн засгийн уналтанд байгаа хэмээн тодорхойлогдож байсан. Тиймээс тухайн үед аж үйлдвэрчлэл гэдэг нь шинэ байгуулагдсан улсын бүх асуудлыг шийдвэрлэж өгнө хэмээн тодорхойлогдсон. Үүнээс хойш 20-иод жилийн турш, Солонгосын цэргийн элитүүд эдийн засгийн байгуулалт болон аж үйлдвэрчлэлийг байгуулахыг улсын зорилго болгосон.

Бослогыг удирдсан цэргийн хүчин нь улс төрийн хүрээгээр гадна эдийн засгийн хүрээнд ч өргөн ажилласан. Пак Жонг Хый ерөнхийлөгчийн засаглалын хугацаанд дэд даргаас дээш албан тушаалтай эдийн засгийн ажилчидын 33.16% нь хуучин цэрэг байсан хүмүүс байсан.

### 3. Пак Жонг Хый засаглалын эрх мэдлийн бүтцийн онцлого

Пак Жонг Хый засаглал үүссэнээс хойш төрөөс үүдэлтэй эдийн засгийн хөгжлийн бодлогыг гүйцэтгэх нь бусад нийгмийн бүлэгтэй харьцуулахад улс төрийн эрх мэдлийн харьцааг хэт ихэсгэсэн. Пак Жонг Хый засаглалын эрх мэдлийн бүтэц нь нам (ардчилсан социализмын нам), дотоод хэсэг, төв мэдээллийн хэсэг, ерөнхийлөгчийн бие хамгаалах газар, мөн цэргийн хүчин зэрэг гол эрх мэдэлт байгууллагуудаар үүсгэдсэн байсан. Пак Жонг Хый ерөнхийлөгч нь уг эрх мэдэлт байгууллагуудыг тус бүр өөртэй нарийн нягт холбоотой босоо харилцааны системийг тогтноход хүргэсэн бөгөөд нөгөө талаас уг эрх мэдэлт байгууллагуудын хамтын ажиллагааны үүслийг хязгаарласан. Ийм эрх мэдэлт байгууллагуудын талаарх нөлөө бүхий хязгаарлал нь хуваарилалт бүхий захиргаадалыг (divide and rule) боломжтой болгосон. Хоорондоо тус бүрийн өрсөлдөх харилцаатай байгаа улс төрийн эрх мэдэлтэнгүүд тус эрх мэдэлт байгуулага бүрийн дарга болсноор тэгс дуулгавартай болох ба, онцгойлон энэ үе шатанд Пак ерөнхийлөгч дотоод хэсэг юм уу намтай харьцуулахад дотно харилцаатай байгаа ерөнхийлөгчийн бие хамгаалах хэсэг болон төвийн мэдээллийн хэсэгт том эрх мэдлийг олгон өөрийн хувийн эрх мэдлийн суурийг тавьсан.

Онцгойлон олон эрх мэдэлт байгууллагуудаас төвийн мэдээллийн хэсэг (KCIA) нь хуулийн эрх мэдлийг сууриа болгон Пак Жонг Хый заагалалын хамгийн чухал улс төрийн үйл явдалд гол үүрэг гүйцэтгэсэн. Ардчилсан социализмын намын байгуулалт, Солонгос Японы ярилцлага явуулах болон Өмнөд Хойд Солонгосын ярилцлага зэрэг, ерөнхийлөгчийн нарийн бичгийн хэсэгтэй хамтран Пак Жонг Хый засаглалыг оршин тогтноход чухал үүрэг гүйцэтгэсэн.

Гэвч Пак Жонг Хый ерөнхийлөгч нь өөрийн засаглалыг барин, олон улс төрийн бодлогыг шийдвэрлэж байсан төвийн мэдээллийн хэсэг, ерөнхийлөгчийн нарийн бичгийн хэсэг, нам, ерөнхий сайд зэрэг аль нэг талд ч их хэмжээний хүч өгөөгүй. Тус эрх мэдэлт байгууллагуудыг хоорондоо өрсөлдөх байдалд оруулан аль нэг байгууллага захиргаадахгүй болгосон ба, ингэснээр Пак Жонг Хый

[2] Bottomore, Elite and Society. Penguin Books. Ltd. 1976. p 105
[3] Putnam Robert D. 1976. *The Comparative Study of Political Elite*., Englewood Cliffs. N.J. .Prentice Hall, p5

5.16 Хувьсгалд том үүрэг гүйцэтгэсэн ба, төвийн мэдээллийн хэсэг болон ардчилсан социализмын намыг байгуулан Пак Жонг Хый засаглал оршин тогтоноход том үр нөлөө үзүүлсэн Ким Жунг Пил нь дараагийн ерөнхийлөгч болно хэмээн тооцогдож байх хэмжээгээр төв намын дотор том авсан ба. Пак Жонг Хый ерөнхийлөгч нь үүнээс болгоомжилсон. Пак Жонг Хый ерөнхийлөгчийн хязгаарлалт болон эсрэг хүчиний хавчлагаас болж түр албан тушаалаа бууж гадаад улсад оршиж байсан хэдий ч. Пак Жонг Хый ерөнхийлөгчийн засаглалын хугацааг сунгахын төлөөх 3-р сонголтын хууль өөрчлөгдөх болон 10 сард системийн шинэчлэлтэнд тусласнаар улс төрд дахин орж ирсэн.

Үүнээс хойш 1971 оноос 1975 оныг хүртэл ерөнхий сайд байсан ба идэвхитэй дотоод гадаадын үйл ажиллагаагаар дамжуулан өөрийг нь дэмжигч хэсгийг тэлж явсан. Ким Жунг Пил улс төрийн 2-догч эрх мэдэлтэн нь ил тод болоход. Пак Жонг Хый ерөнхийлөгч түүнийг ерөнхий сайдаас халдаг.

1979 онд Пак Жонг Хый ерөнхийлөгч нас барсаны дараа, ардчилсан социализмын намын даргаар сонгогдон дараагын ерөнхийлөгчийн сонгуульд бэлтгэх болдог. Гэвч 1980 он шинэ цэргээр дамжуулан ардчилсан социализмын нам хүчээр тарж, Ким Жунг Пил улс төрөөс тэтгэвэрт гарах болсон.

(2) И Хү Раг

5.16 Бослогын үед улс сэргээх хурлын сурталчилгааны хэсгийн дарга байсан бөгөөд 1963 оноос эхлэн Пак Жонг Хый ерөнхийлөгчийн нарийн бичгийн дарга байсан. 1970 онд төвийн мэдээллийн хэсэгийн дарга болсон. 1971 онд 7-р ерөнхийлөгчийн сонгуульд нийт удирдах эрх мэдэлтэйгээр Пак Жонг Хый ерөнхийлөгчийн 3 сонголтонд нэмэр оруулсан. 1970 оны эхээс эхлэн Хойд Солонгостой олон удаа дараалан хэлэлцүүлэг хийн 1972 онд 7.4 Хойд Өмнөдийн хамтарсан гарын тайлан[6] тавихын өмнө Хойд Солонгос-д олон удаа очин Хойд Өмнөдийн хэлэлцүүлгийг эхлүүлэн Хойд Өмнөд зохицуулах газрын хамтарсан даргаар Пхеньян болон Сөүлд Хойд Солонгос болон Өмнөд Солонгосын хэлэлцүүлгийг удирдсан.

И Хү Раг нь тухайн үед Пак Жонг Хый ерөнхийлөгчийн хамгийн ойрын хү байсан хэдий ч, улс төрийн 2-догч, мөн Пак Жонг Хый ерөнхийлөгчийн өв залгамжлах хүн гэсэн цуу яриа тарснаар халагдах аюулд тулгардаг. Үүнээс зугтан гарахын тулд Пак Жонг Хый ерөнхийлөгчийн хамгийн том дайсан байсан эсрэг намын улс төрч Ким Дэ Жүнг-ийг Японоос хулгайлан алахыг оролдсон боловч бүтэлгүйтэж,[7] төвийн мэдээллийн хэсэгийн даргаас халагдсан.

(3) Ким Жэ Гюү

Пак Жонг Хый засаглалын эхэнд цэргээр ажиллаж байснаа 1973 онд УИХ-ын гишүүн болон улс төрд орсноос хойш, барилгын хэсгийн дарга зэргээр ажилласан. 1976 онд төвийн мэдээллийн хэсгийн даргаар томилогдсоноос хойш ерөнхийлөгчийн бие хамгаалах газрын дарга Ча Жи Чольтой үргэлжлүүлэн эсрэг харьцаатай байсан. Ча Жи Чольтойх эсрэг харьцаанд тэр ялагдах байдалтай байсан.

Ча Жи Чольтойх үргэлжилсэн эсрэг харьцааны дунд. 1979 оны 8 сарын 11-ны өдөр импорт экспортын эмэгтэй ажилчны бослого,[8] 10 сарын 4-ны эсрэг нам болох Шин Мин намын дарга Ким Ёнг Сам УИХ-ын гишүүдийн хасагдах үйл явц,[9] 10 сарын 16-ны иргэдийн тэмцэл[10] зэрэг үргэлжилсэн төрийн тогтвортой бус үйл явцуудыг харан, системийн шинэчлэлтийн зөв эсэхэд эргэлзэж эхэлсэн.

[6] Хоёр талын нэгдлийн зарчм: нэгдүгээрт, нэгдэл нь гадны оронд найдах юм уу хамааралгүйгээр өөрсдөө бүтээх ёстой. хоёрдугаарт, нэгдэл нь хоорондоо нөгөө талыг эсэргүйцсэн хүч хэрэглэсэн ажил хийлгүй энх тайван байдлаар бүтээгдэх ёстой. Гуравдугаарт, үзэл бодол, үнэт зүйл, системийн ялгааг даван юуны түрүүнд нэгэн үндэстэний хувьд үндэсний нэгдлийг санаачлах ёстой

[7] 1971онд ерөнхийлөгчийн сонгуулд эсрэг намын Ким Дэ Жүнг нь Пак Жонг Хый ерөнхийлөгчид маш бага ялгаагаар хожигдсон. Үүнээс хойш Ким Дэ Жүнгд том жижиг осол дараалан бий болсон. Өөрийн аюулыг мэдэрсэн Ким Дэ Жүнг нь Япон руу эмчилгээ хийлгэхээр гарсан ба Японд төвийн мэдээллийн хэсгийн ажилчидад хулгайлагдан алуулах аюулд тулгарсан. Хулгайлагдсаны 5 хоногын дараа Ким Дэ Жүнг нь Сөүлд олдсон

[8] Хиймэл үс экспортлогч компани болох ҮН экспорт импорын компаны эмэгтэй ажилчид компаныг хаасанд эсэргүүцэн эсрэг нам болох Шин Мин намын байранд бослого гаргасан үйл явц юм. Цагдаа нь хүчээр тараан, баривчилсах үйл ажиллагаа явуулсан ба энэ үйл явцад нэг ажилчин нас барах болдог. Энэ үйл явцын дараа, олон ардчилалын хөдөлгөөн олон талаас хамтран системийн шинэчлэлтийн эсрэг тэмцэх болсон

[9] Тухайн үеийн эсрэг нам болох Шин Мин намын дараг байсан Ким Ёнг Сам Нью Йорк Таймстайх ярилцлагын явцад АНУ нь Пак Жог Хый засаглалын тухайд дэмжлэгийг татан Солонгосын төрийг ардчилалын засаглалтай болгоход дарамт үзүүл хэмээн хэлсэн. Үүнд үндсэн намын гишүүд Ким Ёнг Сам Шин Мин намын даргыг УИХ-ын гишүүнээс халсан ба үүнд эсрэг намын гишүүд бүлгээр ажилаа хаян тэмцсэн.

[10] 1979оны 10сарын 16нд, Бү Сан хот болон Гюнг Сан өмнөд аймаг Ма Сан хотод системийн шинэчлэлтэнд хандсан тэмцэл болсон. Бү Сан Их Сургуулийн оюутнууд системийн шинэчлэлтийг эсэргүүцэн бослого гаргасан ба иргэд бослогонд оролцсоноор Ма Сан хэсгийг хүртэл ардчилалын бослого өргөжсөн. Пак Жонг Хый засаглал нь Бү Санд тушаалаа гарган цэргийг оруулж бослогыг дарсан

Үүнтэй зэрэгцэн улсын цэгцлэх ажиллагааг тойрон хүчтэй үзэл бодолтой ерөнхийлөгчийн бие хамгаалах газрын дарга Ча Жи Чольтой ноцтой зөрөлдсөн ба Ча Жи Чолийг дэмжиж байгаа Пак Жонг Хый ерөнхийлөгчийн талаарх эсрэг үзэл бодол болон үл итгэлцэлтэй болсон.

1979 оны 10 сарын 26-ны орой, Пак Жонг Хый ерөнхийлөгч болон Ча Жи Чоль ерөнхийлөгчийн бие хамгаалах газрын даргатай хоол идэж байх үед Ча Жи Чольтойх маргааны эцэст Ча Жи Чоль бие хамгаалах газрын дарга болон Пак Жонг Хый ерөнхийлөгчийг буугаар буудан алсан.

2) Ерөнхийлөгчийн бие хамгаалах газар

Ерөнхийлөгчтэй хамгийн ойролцоо байдаг ба удаан хугацааг хамт өнгөрүүлдэг хүн нь ерөнхийлөгчийн аюулгүй байдлыг хариуцаж байгаа бие хамгаалах газрын дарга юм. Солонгос шиг хилээ голд байлган Хойд Өмнөд Солонгос харьцаж байгаа нөхцөлд ерөнхийлөгчийн аюулгүй байдлыг хариуцдаг бие хамгаалах газрын даргын нэр хүнд үргэлж өндөр байсан ба заримдаа бие хамгаалах хүрээг даван эрх мэдэлтэн болж байсан удаа бий.

Пак Жонг Хый ерөнхийлөгчийн эхнэр болон Юүг Ёнг Сү хатагтай Хойд Солонгосын явуулсан алуурчинаар дамжуулан алагдсан ба, Пак Жонг Хый ерөнхийлөгч нь тухайн үед үндсэн намын УИХ гишүүн байсан Ча Жи Чолийг бие хамгаалах газрын дарга болгон томилдог. Ча Жи Чоль нь хуучин цэрэг байсан ба 1961 оны 5.16 бослогын үед Пак Жонг Хый улс сэргээх хамгийн дээд хурлийн даргын бие хамгаалах дэд дарга хийж байсан. 1963 онд Пак Жонг Хый ерөнхийлөгч болоход үндсэн намын УИХ гишүүн болон 1974 онд ерөнхийлөгчийн бие хамгаалах газрын даргаар томилогддог. Үүнээс хойш Пак Жонг Хыйгийн итгэлийг аван асар том эрх мэдэлтэй болсон. Тэр ерөнхийлөгчийн нэр төрийг ашиглан ерөнхийлөгч бие хамгаалах газрын үүрэг болон нэр төрийг томоор өргөжүүлсэн. Мөн 'ерөнхийлөгч бие хамгаалах хурал' гэсэн онцгой байгууллага байгуулж төвийн мэдээллийн хэсгийн дарга, цэргийн хэсгийн дарга, дотоод хэсгийн дарга, хайгуулын газрын дарга, цагдаагын газрын дарга, газар, далай, агаарын цэргийн дарга зэргийг гишүүд болгон өөрөө дарга болсноор улс төрийн 2-догч эрх мэдэлтэн гэдгээ харуулсан.

Тэр ерөнхийлөгчийн энгийн ерөнхийлөгчийн бие хамгаалах түвшинг даван ерөнхийлөгчийн эрх мэдлийг батжуулдаг засаглалын хамгаалагчын үүргийг гүйцэтгэсэн.[11]

**4. Эдийн засгын бодлого**

1) 1960аад оны экспортод тулгуурласан аж үйлдвэрийн хөгжлийн систем

1950-иад онд Солонгосын эдийн засаг гадны орны тусламжинд найдах хэрэгтэй байсан ба энэ нь И Сүнг Ман засаглалаар дамжуулан Воны хэтрүүлэн үнэлэхүйг дэмжихэд хүргэсэн. Мөн 1957 оноос эхлэн гадны орнуудаас тусламж багасахад эдийн засгийн бүтцийг дахин боловсруулахгүй байх аргагүй болсон. Ийм байдал нь улс төрийн зөвт байдлын хувьд дутмаг байсан Пак Жонг Хый ерөнхийлөгчийг идэвхитэй эдийн засгийн хөгжлийг явуулахад хүргэсэн. Тэр маш бага улсын доторх зах зээл, сул хөрөнгө хураалт, буурсан техникийн нөхцөл байдлыг экспортыг эрхэмлэсэн аж үйлдвэрчлэлийн бодлогоор дамжуулан шууд туулж гарснаар үйлдвэрлэлийн бүтцийн аж үйлдвэрийн бүтцийг шинээр байгуулсан ба, гадна төрхөнд Пак Жонг Хый засаглалын хөгжлийн бодлого амжилттай болсон мэт харагдсан.

Макро эдийн засгийг бүрдүүлдэг худалдан авалт, хөрөнгө оруулалт болон улс төрийн зарлага нь гадны орны тусламжид шууд холбоотой байсан тухайн үеийн байдалд гадны улсуудаас тусламж тасрах нь улс төрд их хэмжээний хэцүү байдлыг учируулсан. Эдийн засгийн хөгжлийн төлөөх нийт хэрэгцээний өсөлт, удаан хугацааны нийлүүлэх чадварыг олох, мөн хөдөө аж ахуйн асар том ажилгүйчдийг шингээхийн зэрэгцээ сэтгэл хангалуун байдлыг өгөж чадах зүйл нь хөрөнгө оруулалтыг ихэсгэхээс өөр зүйл байгаагүй. Гэвч хөрөнгө оруулалтыг ихэсгэхийн төлөөх зах зээлийн үүсэл болон хөрөнгө оруулалт хийх нь гадны хөрөнгийн оруулж ирэх болон экспорт байсан.

Пак Жонг Хый засаглал гарч ирсэн эхэн үед экспорын талаарх анхаарулга хүчтэй явагдсан. Улс даяар 'экспорт биш бол үхэл' эсвэл 'экспорт бидний амьдрах зам' гэсэн үгс гарч ирж эхэлсэн ба үүний төлөөх гол эдийн засаг, нийгмийн системийн өөрчлөлт даган гарж ирсэн. 1964 оны 5 сарын 3-нд, вальютын ханшыг 1доллар тутам 130 воноос 255 вон хүртэл ихээр өсгөснөөр воны ханшыг бодит болгон импортыг хязгаарлан экспортыг илүү хялбар болгосон.

Ийм эдийн засгийн хөгжлийн бодлогын үр дүн маш том байна. 1966 оныг хүртэл жилийн дундаж эдийн засгын хөгжлийн түвшин 8.5% хүрсэн ба, хөрөнгө оруулалтын түвшин 18.2%д хүрсэн. Ижил

[11] 1979онд ардчилалыг шаардаж байгаа иргэдийн бослого улс даяар хүчтэй болоход Камбожид засаглалаа барихын тулд 3 сая хүн алсан байхад Солонгосод 1-2 саяыг алахад зүгээр гэж хэлсэн.

нам нь 33.9% санал авч саналын ялгаа дөнгөж 1.1% л байсан. Эцэст энэ сонгуулийн дараа Пак Жонг Хый ерөнхийлөгч нь тухайн үеийн эдийн засгийн бодлогыг боловсруулан явуулсан эдийн засгийн элитүүдийг халснаар, Пак Жонг Хый засаглалын эдийн засгын бодлого химийн үйлдвэрт суурилсан хөгжлийн бодлогоос эдийн засгын тогтвортой байдал болж өөрчлөгдсөн.

**5. Пак Жонг Хый эдийн засгийн бодлогын үнэлгээ**

Капиталист улсын хөгжлийн онол (capitalist developmental state)-д улсын зориудын 'үнийн өөрчлөл (getting prices wrong)'-ийг хурдтай аж үйлдвэрчлэлийн хөдөлгүүр хэмээн үзэж байна. Тиймээс улсын хүчтэй эдийн засгын хэсгийн хязгаарлалтаар үүссэн аж үйлдвэрийн болон боловсруулах бодлого хурдтай хөгжлийн үндэс хэмээн үнэлж байна.

Пак Жонг Хый ерөнхийлөгч нь бослогын дараа зөвт бус эрх мэдлийг зөвтгөхийн тулд эдийн засгын хөгжилд анхаарсан ба эдийн засгын хөгжил гэсэн нэрийн дор эрх мэдлийг төвд төвлөрүүлсэн. Түүний үр дүнд бүх улсын эрх мэдэл нь Пак Жонг Хый ерөнхийлөгчид төвлөрсөн ба төвлөрсөн эрх мэдэл нь хэд хэдэн хамгийн ойр хүмүүсээр дамжуулан хэрэгжсэн.

Мөн эдийн засгын хөгжлийн төлөвлөгөөг биелүүлэхийн тулд хэрэгцээтэй гадны хөрөнгийг иргэдийн эсэргүүцэл байсан хэдий ч Японтой хамтийн гэрээгээр дамжуулан хохирол барагдуулах хөрөнгө болон зээлийг авсан ба олон цэргийг Вьетнам руу явуулсан. Гэвч ийм байдлаар Пак Жонг Хый засаглалын эдийн засгын үр дүн нь амжилттай байх тусам иргэдийн эсэргүүцэл илүү их болсон. хурдтай аж үйлдвэрчлэл нь ардчилалын хөдөлгүүрийг хүчирхэгжүүлэн Пак Жонг Хый ерөнхийлөгчийн захиргааны байдлын талаарх эсэргүүцлийг батжуулсан.

Пак Жонг Хый ерөнхийлөгч алуулан, системийн шинэчлэлт төгссөн хэдий ч нийгмийн талаас Пак Жонг Хый-гийн үеийн эдийн засгын бодлого нь хоёр өв үлдээсэн. Нэгдүгээрт, Пак Жонг Хый засаглалын үеийн эдийн засгын аюулт байдлаас төрийн хандсан арга нь цаашид эдийн засгын хөгжил нь хамгийн дээд гэсэн үзэл бодлыг үүсгэн нийгмийн зөвт байдлыг тасралтгүйгээр золиослуулах байдалд хүргэсэн. Хоёрдугаарт, эдийн засгийн аюул бүр улс болон хөрөнгийн хамтийн ажиллагаа нь хүчирхэг хөрөнгийг үүсгэсэн. Солонгосын том компанууд Пак Жонг Хый ерөнхийлөгч засаглалын үед улс төрийн олон янзын давуу эрх болон дэмжлэгийг аван том болж хөгжсөн. Энэ үед үүссэн хөрөнгийн хүч нь 'хөрөнгөтөний бүтэц' болж үлдсэн хэдий ч үүнийг хянан, хязгаарлах боломжтой ардчилсан нийгмийн бодлого хангалттай хөгжиж чадаагүй. Энэ нь өнөөдөр жижиг компанууд болон том компани, ажилчин болон компанийн хооронд үүсдэг олон янзын нийгмийн асуудлыг үүсгэх шалтгаан болсон.

## НОМ ЗҮЙ


1. 김낙년, 1999, "1960년대 한국의 경제성장과 정부의 역할", 경제사학, 27
2. 김보현, 2006. 박정희 정권기 경제개발: 민족주의와 발전, 갈무리.
3. 백낙청, 2005, "박정희 시대를 어떻게 생각할까", 창작과 비평, 33권 2호.
4. 서익진, 2003, "한국산업화의 발전양식", 이병천 엮음, 개발독재와 박정희시대: 우리시대의 정치경제적 기원, 창비.
5. 임혁백, 1992, "한국의 자본주의적 발전과 정치적 민주화의 상관관계", 21세기 한국의 정치와 경제, 서울대 한국정치연구소.
6. 한배호, 2003, 한국정치문화와 민주정치, 법문사.
7. Amsden, A. H., 1989, *Asia's Next Giant: South Korea and Late Industrialization*, Oxford Univ. Press.
8. Bottomore, 1976, *Elite and Society*, Penguin Books.
9. Bruce Cumings, 1984, "The Origins and Development of the Northeast Asian Political Economy", *International Organization*, vol 38.
10. Chalmers Johnson, 1982, *MITI and the Japanese Miracle*, Stanford Univ. Press.
11. Michael Brecher, 1963, "Political Instability in the New State of Asia", in Harry Eckstein and david E., Apter, *Comparative Politics*, New york: The Free Press.
12. Putnam Robert D. 1976. The Comparative Study of Political Elite., Englewood Cliffs, N.J. :Prentice Hall.
13. Robert Wade, 1990, *Governing the Market: Economic Theory and the Role of Government in East Asian Industrialization*, Princeton Univ. Press.